



# ДУНГОВЬ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 128

Мандалговь

## Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар 77.3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4 дүгээр бүлгийн 4.2 дахь хэсгийг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг: Төв Халхын дуулалт жүжгийн театр гэрэлтүүлгийн тоног төхөөрөмж шаардлагатай байсан учир, 2014 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдөр хүртэл “Тоног төхөөрөмж түрээслэх, түрээслүүлэх гэрээ”-ний дагуу Ардчилсан намаас гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжүүдийг түрээсэлсэн. Түрээсийн төлбөрийг гэрээний дагуу урлаг соёлоор үйлчлэн төлбөрийн тооцоог дуусгасан. Нийт 69,510,900.00 (жаран сая таван зуун арван мянга есөн зуу) төгрөгийн балансын үнэтэй тоног төхөөрөмж нь түрээсийн хугацаанд нийт 37,996,006.00 (гучин долоон сая есөн зуун ерэн зургаан мянга зургаа) төгрөгөөр элэгдэн, 27,514,894.00 (хорин долоон сая таван зуун арван дөрвөн мянга найман зуун ерэн дөрөв) төгрөгийн үлдэх өртөгтэй болсон. Тус тоног төхөөрөмжийг үлдэх өртгөөр нь Төв Халхын дуулалт жүжгийн театрт бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр: Төв Халхын дуулалт жүжгийн театрын дарга Д.Доржсүрэнд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай: Үүнд:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 01 дүгээр сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР